



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 11 сарын 25 өдөр

Дугаар 298

Улаанбаатар хот

Г

Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт  
оруулах тухай

Т


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.2, Компанийн тухай хуулийн 51 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 408 дугаар тогтоолоор баталсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 5.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мандал даатгал” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нэг бүр нь 1000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 6,243,016 /зургаан сая хоёр зуун дөчин гурван мянга арван зургаа/ ширхэг энгийн хувьцааг 100 /нэг зуу/ хувааж, нэг бүр нь 10 /арав/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 624,301,600 /зургаан зуун хорин дөрвөн сая гурван зуун нэг мянга зургаан зуу/ ширхэг энгийн хувьцаа болгон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Лхагвасүрэн/-т, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Мандал даатгал” ХК-ийн хувьцааг хуваахтай холбоотой ажиллагааг ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэж, холбогдох тайланг ирүүлэхийг “Монголын хөрөнгийн бирж” ХК/Х.Алтай/, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /Ж.Байгалмаа/-д тус тус үүрэг болгосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН